

Герман Улс Нэгдсэн өдөр 2026

Холбооны Бүгд Найрамдах Герман Улсаас Монгол Улсад суугаа элчин сайд

Эрхэмсэг ноён Томас Графын хэлэх үг

Улаанбаатар хот, 2025 оны 9-р сарын 17-ны өдөр

Монгол Улсын Эдийн Засаг, Хөгжлийн Дэд Сайд, хатагтай С. Даваасүрэн,

Эрхэм хүндэт гишүүд ээ, эрхэмсэг хатагтай, ноёд оо,

эрхэм хамтран ажиллагсад аа, хүндэт зочид оо,

Герман Улс эргэн нэгдсэн үндэсний баярын өдрийг энэ өдөр та бүхэнтэй хамт тэмдэглэж байгаадаа би маш их баяртай байна. Ялангуяа миний хувьд Герман Улс эргэн нэгдсэний энэхүү баярын өдрийг Улаанбаатар хотод тэмдэглэж буй анхны хүлээн авалт учраас бүр ч их баяртай байна. Та бүхэн ийнхүү олноороо хүрэлцэн ирсэнд баярлалаа.

10 дугаар сарын 3-нд Герман улс эргэн нэгдсэн түүхэн өдрийн 36 дахь жилийн ой тохиож байна. Энэ өдөр нь манай улс, нийслэл Берлин хот төдийгүй Европ бүхэлдээ хуваагдсан байсан цаг үе эцэс болсны илэрхийлэл билээ. Германы нэгдэл нь тайван замаар, ардчилсан үйл явцын үр дүнд бий болсон бөгөөд энэхүү үйл хэрэгт олон мянган хүн хувь нэмрээ оруулсныг бид дурсдаг. Германы эргэн нэгдлийг бодит үйл хэрэг болгосон эдгээр хүмүүст бид өнөөдөр ч чин сэтгэлээсээ талархаж байна.

Хүйтэн дайныг ардаа орхиж, Европт энх тайвны шинэ эрин үеийг эхлүүлнэ гэсэн бидний найдвар харамсалтай нь бүрэн биелээгүйг бид мөн мэднэ. Германы эргэн нэгдлийг боломжтой болгож, бидний түшиг тулгуур байж ирсэн дэлхийн дэг журам улам бүр дарамт шахалтад орж байна. ОХУ-ын Украинд явуулж буй түрэмгий дайн эдүгээ тав дахь жилдээ үргэлжилж, өдөр бүр хэмжээлшгүй их хүнийг зовлон шаналалд нэрвэгдүүлж байна. Энэ дайны үр дагаврыг бид энд, Монгол Улсад ч мөн мэдэрч байна. Нэмээд эрчим хүчний хангамж, хүнсний аюулгүй байдал болон аж үйлдвэрийн салбарын нийлүүлэлтийн сүлжээнд дэлхий нийтээр нөлөөлж буй бусад хямралууд гарч байна.

Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас илт тодорхой болж буй сөрөг үр дагавар нь дэлхий даяар хүний амьдрал төдийгүй амьд ертөнцийн үндэс суурийг заналхийлж байна. Бидний нийгэм, эдийн засаг гүн гүнзгий, зарим талаар урьд өмнө тулгарч байгаагүй шинэ сорилтуудтай нүүр тулж байна. Үүнд эрчим хүчний хангамжийг нүүрстөрөгчөөс ангижруулах үйл явцаас эхлээд хиймэл оюун ухааныг хариуцлагатайгаар ашиглах хүртэлх олон асуудал багтана.

Эдгээр хямрал, сорилтыг даван туулахын тулд олон талт үзэл, олон улсын хамтын ажиллагаа урьд өмнөхөөсөө илүү чухал болжээ. Нийтлэг шийдлийг эрэлхийлж тогтооход Монгол Улс найдвартай түнш хэвээр байгааг харахад таатай

байна. Энэ боломжийг ашиглан Монгол Улс НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенцын Талуудын бага хурал болох COP17-г амжилттай зохион байгуулсан та бүхэнд баяр хүргэе.

Герман, Монгол Улс нь олон жилийн түүхтэй, өргөн хүрээтэй, гүн итгэлцэлд тулгуурласан түншлэлээр холбогддог. Энэхүү харилцааг Холбооны Ерөнхийлөгч Штайнмайерын 2024 онд Монгол Улсад хийсэн төрийн айлчлалын үеэр „Стратегийн түншлэл“-ийн түвшинд хүргэсэн билээ. Манай хоёр улсын хоорондын эрчимтэй харилцаа энэ онд ч мөн дээд түвшинд үргэлжилж байгаа нь хоёр орны онцгой харилцааг улам тодотгож байна.

2026 он бол Герман, Монголын харилцааны хувьд онцгой жил юм. Учир нь 100 жилийн өмнө яруу найрагч Дашдоржийн Нацагдорж тэргүүтэй Монголын анхны оюутнууд Германд суралцахаар очсон билээ. Тэд манай хоёр орны хоорондын харилцааны анхны гүүрийг тавьсан хүмүүс байсан. Боловсрол, шинжлэх ухаан, соёлын салбар дахь хамтын ажиллагаа өнөөг хүртэл хоёр талын харилцааны чухал тулгуур хэвээр байгаад бид баяртай байна. Энэ амжилттай хамтын ажиллагааны тод илэрхийлэл болсон олон зүйлийн нэг нь Налайх дахь Герман-Монголын Ашигт малтмал, технологийн их сургууль юм.

Шинээр томилогдсон Элчин сайдын хувьд, Монголын хэчнээн олон иргэн герман хэлийг маш өндөр түвшинд эзэмшсэнийг харах бүрдээ би гайхан, бахархан биширдэг. Герман, Монгол манай хоёр улс уур амьсгал, байгаль орчин, эрчим хүчний бодлогоос эхлээд аюулгүй байдлын салбар дахь хамтын ажиллагаа хүртэл олон чиглэлээр нягт хамтран ажиллаж байна. Мөн хоёр орны эдийн засгийн харилцааг цаашид улам эрчимжүүлэх зорилгод бид байр суурь нэгтэй байгаа.

Герман, Монголын “Стратегийн түншлэл”-ийн харилцааг цаашид бодит агуулгаар баяжуулж, энэхүү түншлэлийг өдөр бүр тодорхой үр дүнгээр амьлуулж, Монгол болон Германы ард иргэдэд үр өгөөжөө өгдөг харилцаа болгон хөгжүүлэхийн төлөө хамтран ажиллая гэж хэлэхийг хүсэж байна.

Энэхүү түншлэлийн гол хөдөлгөгч хүч нь хоёр орны харилцааг хөгжүүлэхийн төлөө өдөр бүр хүчин чармайлт гаргаж буй хүмүүс, иргэд юм. Үүнд Монгол Улсад ажиллаж, амьдарч буй миний эх орон нэгтнүүд ч багтана. Тэдэнд Германы эргэн нэгдэл - үндэсний баярыг тохиолдуулан чин сэтгэлийн мэндчилгээ дэвшүүлье.

Өнөөдрийн баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулахад хувь нэмрээ оруулсан нийт хүмүүст талархал илэрхийлье.

Герман, Монголын найрамдлын төлөө, мөн энэхүү найрамдлыг өдөр бүр бий болгож, хөгжүүлэн баяжуулж байдаг хүмүүсийн төлөө энэ хундагыг өргөө!

Та бүхэндээ 2026 оны Герман улс эргэн нэгдсэн баярын өдрийг сайхан тэмдэглэн өнгөрүүлэхийг хүсэн ерөөе.